



НИЙГМИЙН ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248
дугаарын утаснаас лавлана уу?

Л.Жаргалсайхан

Аймгийн Ерөнхий аудитор

өрөөний утас 70272582

Ц.Саранчимэг- Ахлах аудитор

өрөөний утас 70273204

Аймгийн Аудитын газар

Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	5
• Гол шийдлүүд	6
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	6
• Аудитын санал дүгнэлт	6

**Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн 2013 оны Санхүүгийн Тайланд
аймгийн Аудитын газар аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг, дотоод хяналт бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

1. Ажилтнуудад амралттай байх хугацаанд хоолны мөнгө болон цалингийн нэмэгдэлийг илүү бодож олгосон, татварын хөнгөлөлтийг илүү суутгаж нийт 2040.2 мянган төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ.
2. Аудитын үйлчилгээний төлбөр 1120.0 мянган төгрөг гэрээгээр төлөхөөс 1020.0 мянган төгрөгийг төлж 100.0 мянган төгрөг дутуу төлснийг тайланд өглөгөөр тусгаагүй байна.
3. Эзэмшиж байсан хөрөнгөө өөрийн хариуцлагагүй үйлдлээс болж байгууллагын дотоод журмыг зөрчин албан газраас зөвшөөрөлгүй авч явснаас Баянжаргалан сумын халамжийн мэргэжилтэн 1378.6 мянган төгрөгийн нөөтбүүк, 280.0 мянган төгрөгийн принтер нийт 1658.6 мянган төгрөгийн хөрөнгийг шатааж үрэгдүүлсэн байна.
4. 2012-2013 оны улсын хөрөнгө оруулалтаар ахмадын сувилал баригдаж 2013 онд ашиглалтанд орсныг хүлээн авсан тухай Төв аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн 2013 оны үйл ажиллагааны үр дүнгийн тайландаа тайлагнасан байна. Хөрөнгө оруулалтын гэрээгээр ахмадын сувилалын барилга 998498.7 мянган

төгрөгөөр баригдаж аймгийн ГХБХБАлба хүлээн авч уг хөрөнгийг НХҮХэлтсийн данс бүртгэлд орлого авхуулахаар аймгийн СТСХэлтсээс албан тоот явуулсан боловч уг хөрөнгийг орлогот аваагүй данс бүртгэл тусгаагүй байна.

Ерөнхий менежерээс аймгийн Аудитын газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү.

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн дээрх дурьдагдсан алдаа зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага бичигдсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа

Ерөнхий Аудитор 2014 оны 2-р сарын 12-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Төв Аймгийн Аудитын Газар

Танилцуулга

1. Бид Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх

Аймгийн Аудитын газар жилийн санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалтын үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолыг үндэслэн НХҮХэлтэс нь Захиргаа хяналтын алба байгуулан ажиллаж байна. Захиргаа хяналтын албанаас Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх журмыг батлан мөрдөж ажилласан байна. Энэхүү журамд нийтлэг үндэслэл, хяналт шинжилгээ үнэлгээний зорилго, хяналт шинжилгээ үнэлгээний хамрах хүрээ, тайлагнах хугацаа, хэлтсийн үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зохион байгуулалт /үүнд 1. Үндсэн чиг үүрэг, бодлого, шийдвэрийн хэрэгжилт, 2. Төсвийн хөрөнгө, санхүү, сангуудын үйл ажиллагаа, 3. Гэрээ, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хамтран ажилладаг байгууллагуудын үйл ажиллагаанд хийгдэх хяналт шалгалт, / хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлал, дотоод хяналт шалгалтын үр дүнг хэрэгжүүлэх, хариуцлага, бусад асуудлыг тусгасан байна. 2013 онд байгууллагын дотоод хяналтаас хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөсөн хяналтыг хийж халамжийн сангийн зарцуулалттай холбоотой зөрчлийг илрүүлж алдаа зөрчлийг арилгах талаар ажил хийсэн байна. Гэвч хэлтсийн 2013 оны батлагдсан төсвийн зарцуулалт, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, санхүүгийн үйл ажиллагаанд тодорхой хяналт шалгалт хийгдээгүй байна.

2. Орлого, санхүүжилтийн талаар

Төсвийн сар, улирлын хуваарийг үзэж, хуваарийн дагуу санхүүжилтээ авсан эсэхийг Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн баримтанд шалгахад 2013 онд 475302.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж 2013 оны 10 сард төсвийн хуваарыг тодотгож 494952.4 мянган төгрөгөөр баталсан хуваарийн дагуу санхүүжилт олгосон байна. Нэмж тодотгосон санхүүжилтээс цалин 15000.0 мянган төгрөг, НДШ 1650.0 мянган төгрөг, халаалт 3000.0 мянган төгрөг нийт 19650.0 мянган төгрөг нэмсэн байна. Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн орлогын төлөвлөгөө тодотгосон төлөвлөгөөгөөр 494952.4 мянган төгрөг батлагдсан бөгөөд үүний 494502.4 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр 450.0 мянган төгрөгийг өөрийн орлогоор санхүүжүүлэхээр

батлагдсан байна. 2013 онд төсвийн санхүүжилт гүйцэтгэлээр 499248.9 мянган төгрөг батлагдсанаас 4296.5 мянган төгрөгөөр илүү, туслах үйл ажиллагааны орлогоос 270.0 мянган төгрөг төлөвлөгөө давуулан биелүүлж нийт 4566.5 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр нэмж орсон байна. Харилцахын журналыг сортлон шалгаж мөнгөн гүйлгээний тайлан тэнцэлд үнэн зөв тусгасан байна.

3.Үндсэн хөрөнгө

2013 онд аймгийн ИТХурлын 46 тоот тогтоолоор аймгийн Аудитын газраас 25000.0 мянган төгрөгийн автомашин балансаас балансад шилжин ирснийг орлогоор бүртгэж мөн тогтоолоор 971.8 мянган төгрөгийн тавилга эд хогшилыг Хөдөлмөрийн хэлтэст шилжүүлэн өгснийг балансаас хассан, 2013 оны 12-р сарын 20-ны өдрийн 114 тоот тогтоолоор 6652.2 мянган төгрөгийг тоног төхөөрөмжийг, 40.0 мянган төгрөгийн хөрөнгийн тавилга эд хогшилыг данснаас актлаж устгах шийдвэрийн дагуу данснаас хассан байна. Халамжийн сангийн эх үүсвэрээр бэлтгэгдсэн 1514.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж оны эцэст 328672.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хөрөнгийн тоолого тооцоог хуулинд заасан хугацаанд хийж тооллогын комисс хариуцлагатай ажиллаж тооллогын үр дүнг илтгэх хуудсаар тайлагнаж актлах хөрөнгийн судалгааг гарган шийдвэрлүүлэх талаар холбогдох байгууллагад саналыг хүргүүлж ажилласан байна.

2013 оны жилийн эцсийн тооллогоор Баянжаргалан сумын халамжийн мэргэжилтэний эзэмшиж байсан нөөтбүүк 1378619.13 төгрөг, принтер 280000 төгрөгийн нийт 1658619 төгрөгийн байхгүй байсныг тооллогын комисс илрүүлсэн байна. Эзэмшиж байсан хөрөнгөө өөрийн хариуцлагагүй үйлдлээс болж байгууллагын дотоод журмыг зөрчин албан газраас зөвшөөрөлгүй авч явснаас уг хөрөнгө шатсан байна.

2012-2013 оны улсын хөрөнгө оруулалтаар ахмадын сувилал баригдаж 2013 онд ашиглалтанд орсныг хүлээн авсан тухай Төв аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн 2013 оны үйл ажиллагааны үр дүнгийн тайландаа тайлагнасан байна. Хөрөнгө оруулалтын гэрээгээр ахмадын сувилалын барилга 998498668 төгрөгөөр баригдаж аймгийн ГХБХБАлба хүлээн авч уг хөрөнгийг НХҮХэлтсийн данс бүртгэлд орлого авхуулахаар аймгийн СТСХэлтсээс албан тоот ирсэн боловч уг хөрөнгийг орлого аваагүй данс бүртгэл тусгаагүй байна.

4.Бараа материал

НХҮХэлтэс 2013 онд 14940.0 мянган төгрөгийн бараа материалыг төсвөөс 1773.6 мянган төгрөгийг халамжийн сангийн хөрөнгөөр бэлтгэснийг бүртгэж, 15793.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж 493.0 мянган төгрөгийн бараа материалыг 2013 онд аймгийн ИТХурлын 46 тоот тогтоолоор Хөдөлмөрийн хэлтэст үнэ төлбөргүй шилжүүлж, 499.8 мянган төгрөгийн бараа материалыг хэлтсийн даргын тушаалаар актлаж устгасан байна. Бараа материалын орлогын гүйлгээг харилцах данснаас шилжүүлсэн тохиолдолд авлага өглөгийн дансаар дамжуулан бүртгэсэн байна. Бараа материал дансанд хөтлөгдөх анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад тайлан гаргалт, баримт бүрдүүлэлт орлого, зарлагын баримт, шаардах хуудас зэргийг зохих журмын дагуу холбогдох албан тушаалтан гарын үсэг тамга тэмдэг дарагдсан эсэхийг шалгахад шаардлагын түвшинд хангалттай сайн байна. Бараа материалын тооллогыг чанартай сайн гүйцэтгэсэн байна.

5.Цалингийн талаар

2013 онд нийт 50 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 50 орон тоогоор ажиллажээ. Цалингийн сан 414413.8 мянган төгрөг батлагдсанаас 414305.3 мянган төгрөгний зардал гарч батлагдсан төсвийг 108.5 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Цалинг бодож олгохдоо цаг бүртгэгчээр цагийн баланс гаргуулж ерөнхий менежерээр батлуулсны

дагуу цалинг бодож олгосон байна. Сар бүр цалингийн урьдчилгаа тавьж олгодог бөгөөд суутгалыг нь тухай бүр хийсэн байна. НДШ төлөлтийн тайлангаарх оны эхэнд 76.5 мянган төгрөгийн илүү төлөлттэй санхүүгийн тайланд тусгагдаагүй 78628.7 мянган төгрөгийн НДШ байгуулсан бол өглөгийн тайланд 78552.3 мянган төгрөг буюу 76.3 мянган төгрөгөөр илүү , төлсөн НДШ 78246.4 мянган төгрөг бол өглөгийн тайланд 78552.3 мянган төгрөг 305.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Ажилтнуудад амралттай байх хугацаанд хоолны мөнгө олгосон, нэмэгдэлийг амралттай байх хугацаанд илүү бодож олгосон, татварын хөнгөлөлтийг илүү суутгасан 2040.2 мянган төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ.

6.Бараа үйлчилгээний зардал

Дулаан, цэвэр бохир усны , Шуудан үйлчилгээний газарт явуулсан бичиг болон бичиг хэргийн материалд , цахилгааны зардал, шатахуун, утасны суурь хураамж болон ярианы төлбөр , интернетийн төлбөр хүнсний материал , цэвэрлэгээний материалыг нэхэмжлэхийн дагуу авч мөнгийг шилжүүлж зохих зардлын зүйлээс гаргасан байна. Зардал хооронд шилжүүлсэн тохиолдолд үр дүнгийн тайланд бодит зардлаар тайлагнасан байна. Үүнд түлш халаалт, цэвэр бохир усны зардлаас урсгал зардал , төлбөр хураамж болон бусад зардалд шилжүүлэн зарцуулсныг зөв тайлагнасан байна. Бараа үйлчилгээний зардал хүрэлцэхгүй тохиолдолд хэмнэсэн зардлыг Төрийн сангийн хэлтэст хүсэлт гарган Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалын дагуу төсвийг зарцуулсан байна. НХҮЕГазарт удирдах ажилтны сургалт, Ахмадын чуулга уулзалт, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний чуулга уулзалт, гэр бүлийн үнэ цэнэ үндэсний хэлэлцүүлгийн бүсийн уулзалтанд оролцоход томилолтын зардал 332.0 мянган төгрөгийн олгосон байна. Эдгээрт дээд газраас дуудсан албан бичиг сургалтын хөтөлбөр, урилга зэргийг харилцахын баримтанд үдэгдээгүй байна.

7.Мөнгөн хөрөнгө

Тайланд оны эхэнд болон эцэст үлдэгдэлгүй тайлагнасан байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар 499968.9 мянган төгрөгийн орлого 499968.9 мянган төгрөгийн зарлага гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн гүйлгээ болон харилцахын үлдэгдэл ерөнхий дэвтэр, журнал, санхүүгийн тайланд үнэн зөв тусгагдсан байна. Оны эцсийн зарцуулагдаагүй үлдэгдэл 667.8 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна. Засгийн газрын 2012 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.11.2-т Төсвийн ерөнхий дансанд үлдэгдлийг төвлөрүүлэх тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийхийг зөвшөөрнө гэж заасан байдаг. Тус байгууллага орлого бууруулах бичилтээр бус төсвийн зардалд төвлөрүүлэх шилжүүлэгээр тайлагнасан байна.

Бэлэн мөнгө гаргахдаа Мөнгөн кассын ажиллагааны журам зөрчин заасан дээд хязгаараас хэтрүүлэн 600.0-1408.0 мянган төгрөгийн бэлэн мөнгө гаргаж зарцуулсан байна.

8.Авлага ,өглөгийн талаар

Тайлант онд 1180.0 мянган төгрөгийн авлага, 571321.1 мянган төгрөгийн өглөг үүссэнийг тайлант ондоо барагдуулсан байна. Төв Чандмань ДЭХГазарт 600.0 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна. Аудитын үйлчилгээний төлбөр 1120.0 мянган төгрөг гэрээгээр төлөхөөс 1020.0 мянган төгрөгийг төлж 100.0 мянган төгрөг дутуу төслнийг тайланд өглөгөөр тусгаагүй байна.

Дулаан, цэвэр бохир усны үнэ Төв Чандмань ДЭХГазар 24906.9 мянган төгрөг нэхэмжилсний төлбөрт 25506.9 мянган төгрөг төлж 600.0 мянган төгрөгийн илүү төлөлттэй байна Энэ нь НДХэлтэс тус байгууллагын байрыг түрээслэж байрласны төлбөрөө шууд Төв чандмань ДЭХГазарт төлсөнөөс илүү төлөлт үүссэн байна. Шуудан үйлчилгээний газарт явуулсан бичиг болон бичиг хэргийн материалд 1824.6 мянган

төгрөг, УБЦТС ХХК-ний Зуунмод салбарт хэрэглэсэн цахилгааны зардалд 1471.7 мянган төгрөг, Магнай Трейд ХХК-аас авсан шатахуунд 2818.0 мянган төгрөг, Цахилгаан холбоо ХХК Зуунмод салбарт ярианы төлбөрт 1657.3 мянган төгрөг, Мобинет ХХК-д интернетийн төлбөрт 8712.0 мянган төгрөг, Баянхаан махны захаас махны үнэнд 3093.3 мянган төгрөг, Бүрд трейд ХХК-аас хүнсний материалын үнэ 1920,7 мянган төгрөг, Мандухай цэцэн ХХК-аас цэвэрлэгээний материал болон бичиг хэргийн материалын үнэнд 986.3 мянган төгрөг, Админсофт ХХК интернетийн төлбөр 670.0 мянган төгрөгийн нэхэмжлэхийн дагуу авч мөнгийг шилжүүлж тооцоо нийлсэн актыг үйлдэж баталгаажуулсан байна.

Төв Чандмань ДЭХГазарт 600.0 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна. Аудитын үйлчилгээний төлбөр 1120.0 мянган төгрөг гэрээгээр төлөхөөс 1020.0 мянган төгрөгийг төлж 100.0 мянган төгрөг дутуу төслнийг тайланд өглөгөөр тусгаагүй байна.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудитын явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- ✓ Ажилтнуудад амралттай байх хугацаанд хоолны мөнгө олгосон, нэмэгдэлийг амралттай байх хугацаанд илүү бодож олгосон, татварын хөнгөлөлтийг илүү суутгасан 2040.2 мянган төгрөгийг төлүүлэх
- ✓ Эзэмшиж байсан хөрөнгөө өөрийн хариуцлагагүй үйлдлээс болж байгууллагын дотоод журмыг зөрчин албан газраас зөвшөөрөлгүй авч явснаас Баянжаргалан сумын халамжийн мэргэжилтэнээр шатааж үрэгдүүлсэн 1658.6 мянган төгрөгийн хөрөнгийг төлүүлэх
- ✓ Ахмадын сувилалын барилга 998498.7 мянган төгрөгөийн хөрөнгийг орлогот аваагүй данс бүртгэл тусгаагүй байгаад албан шаардлага өгөх

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

Аудитын стандарт нь аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн санхүүгийн үндсэн хөрөнгийн тодруулгын тайланд ИТХурлын шийдвэрийн дагуу акталж устгах хөрөнгийг нэмж тайлагнаж аудитын явцад залруулсан тул 2013 оны жилийн эцсийн тайланд зөрүүтэй тайлагнагдсан залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

Аудитын үйл явцад аймгийн Аудитын газар хөндлөнгийн шинжээчийн хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ байгууллагын даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Өмнөх зөвлөмжийн биелэлт

2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгөгдөж бүрэн хэрэгжүүлсэн байна

1. Байгууллагын зардлын гүйцэтгэлийг бодитой бус тайлагнах нь төлөвлөгөөг хийх, хянах, батлах, шинжилгээ судалгааны дүнд нөлөөлөх учир төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв тайлагнах

2. Түлээ, нүүрсний хөнгөлөлтийг хавтгайруулж бүх ажилтан албан хаагчдад олгохгүй байх.
3. Төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх.
4. Монгол улсын Засгийн газрын 2011.11.09–ний өдрийн 311-р тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын дагуу дотоод хяналтын журам баталж, комисс байгуулж ажиллах

Аудитын санал дүгнэлт

Аймгийн аудитын газраас ажлын баримтанд үндэслэн дээрх дурьдагдсан алдаа зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага бичигдсэн тул санхүүгийн тайланд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага байгаа тул **Зөрчилгүй санал дүгнэлт** гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар